



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 4/13

Булган сум

“Чадварлаг мэргэжилтэн” хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.2, 4.2.3 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөр батлах тухай IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх “Чадварлаг мэргэжилтэн” хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Э.Мөнх-Очир (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Төлөөлөгч)

А.Оюунжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр эрхлэлт,
нийгмийн хамгааллын бодлого хариуцсан мэргэжилтэн)

Н.Пүрэвсайхан (Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа
Булган аймаг дахь политехникийн коллежийн захирал)
Г.Нямдорж (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын
Хөдөлмөрийн хэлтсийн дарга)

Б.Үүрийнтуяа (Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа
Булган аймаг дахь политехникийн коллежийн
сургалтын менежер)

Ж.Орхонтуул (Боловсролын газрын Ахлах арга зүйч)
Д.Мэндсайхан (Аймгийн Ажил олгогч эздийн холбооны
тэргүүн)

Д.Оюунгэрэл (Монголын Үндэсний худалдаа аж
үйлдвэрлэлийн танхимын Булган аймаг дахь салбарын
дарга)

Л.Саранчимэг (Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн
холбооны тэргүүлэгч)

Нарийн бичгийн дарга: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

2.“Чадварлаг мэргэжилтэн” хөтөлбөрийг орон нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, оновчтой боловсруулж, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулан, 2025 оны I улиралд багтаан батлуулахыг ажлын хэсгийн дарга (О.Ундрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР